



**НЭН ТҮРҮҮНД ХАБ-2017
БАГА ХУРАЛ**

ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР ХОТ

2017.04.12

2017 оны 04-р сарын 11-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Corporate Hotel and Convention Center зочид буудлын Event Hall танхимд Нэн түрүүнд ХАБ-2017 бага хуралд төрийн байгууллагын 125, гадаадын байгууллагын 1, хувийн хэвшлийн 240, үүнээс уул уурхайн салбараас 80, Эрчим хүчний салбараас 40, барилгын салбараас 25, бусад салбарын 95 гаруй нийт 150 аж ахуйн нэгжийн төлөөлөл, төрийн бус болон сургалтын байгууллагын 20 гаруй нийт 365 төлөөлөгчид оролцлоо.

Монгол Улсын ХАБЭА-н үндэсний тогтолцоог боловсронгуй болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ХАБ-ын сургалтын чанарыг дээшлүүлэх, “ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоо. Шаардлага” Монгол Улсын MNS OHSAS 18001:2012 стандартыг нэвтрүүлж ажиллахад Монгол улсын Засгийн газар, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаа чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэн НЭН ТҮРҮҮНД ХАБ-2018 Бага хурал хүртэл хэрэгжүүлэх зорилтыг тодорхойлов.

НЭН ТҮРҮҮНД ХАБ-2017 Бага хуралд оролцсон байгууллага

Байгууллагын ангилал	Байгууллагын нэр
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Яам Уул Уурхай, хүнд үйлдвэрийн Яам Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл Мэндийн Төв Барилга Хот Байгуулалтын Яам Эрүүл мэнд, Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар Стандартчилал, Хэмжил Зүйн Газар Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар Автотээврийн Үндэсний төв
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА	Монголын Үйлдвэрчний Эвлэлүүдийн Холбоо Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо Өргөн Тээвэрлэх Машин Төхөөрөмж Үндэсний Холбоо Нийгмийн тогтвортой хөгжлийн үндэсний нийгэмлэг ТББ Мэргэшсэн ХАБЭА-н Мэргэжилтнүүдийн Холбоо ТББ Монголын Барилгын Үндэсний Ассоциаци Монголын Ашигт Малтмал Баяжуулагчдын Холбоо Монголын Зүрхний Холбоо ТББ

<p>АЖ АХУЙН НЭГЖ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА</p>	<p>Эрдэнэс Монгол ХХК ШУТИС –БАС, БУХС, ГУУС АШУҮИС- Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль, Хөдөлмөр, Орчны Эрүүл Мэндийн Институт Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль ЭСТО ХХК Дархан ДЦС ТӨХК АПУ Трэйдинг Бласт ХХК Номин констракшн девелопмент ХХК Эрдэнэс таван толгой ХК Асартайн говь ХХК Мультипак ХХК Юнигаз ХХК Сүү ХХК Мобиком корпораци ХХК Оюу толгой ХХК Монголросцветмет ХХК Зэрэгцээ алтны үйлдвэр Трансвест Монголиа ХХК Доншен газрын тос ХХК Эрдэнэт үйлдвэр ХХК Шивээ овоо ХХК Архангай аймгийн МСҮТ Улаанбаатар төмөр зам Хөвсгөл дулааны станц ТӨХК Аж мянган ХХК Багануур зүүн өмнөд бүсийн ЦТС ТӨХК Ачит ихт ХХК Энержи ресурс ХХК Петрочайна Дачин Тамсаг ХХК Sandvik Mongolia LLC Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг</p>	<p>Зүүнхараа вагон депо Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба "Нью Семетри" ХХК Улаанбаатар буян ХХК Зун Шин ХХК Зэт Эм И ХХК Хэнтий-Ус ХХК Жи энд Юу ХХК Цагаан-Уул магнит ХХК Mongolian Mining and Exploration LLC ТЭН-ХУН ХХК Хасу Мегаватт ХХК Цог-Өрнөх ОНӨААТҮГ Арева Монгол ХХК Эрдэнэсант АЗЗА ТӨХК ДЦС - 4 ТӨХК ДЦС - 3 ТӨХК Дун Юань ХХК Эм Эс Эм групп ХХК Хишиг арвин индустриал ХХК Мон Энержи ХХК Хос хас ХХК Говь-алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг Эм Жи Жи И Си ХХК Нэмнэ ХХК Гацуурт ХХК Монгол болгаргео ХХК Хөвсгөл Эрчим хүч ХХК Хөхмөнх Сервис ХХК ОШМИ ХХК Орхон аймгийн МХЕГ Цайртминерал ХХК Дархан сэлэнгийн ЦТС ХК Монголын төмөр зам ТӨХК Шим ус ОНӨААТҮГ Багануур ХК</p>
---	--	--

ЗӨВЛӨМЖИЙН ЗОРИЛТУУД:

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх
2. ХАБЭА-н эрх зүйн орчныг боловсронгуй болгох
3. ХАБЭА-н соёлыг төлөвшүүлэх
4. ХАБЭА-н үндэсний тогтолцоог хөгжүүлэх
5. ХАБЭА-н соёл, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

ЗОРИЛТ1. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Үйл ажиллагаа	Хамтран ажиллах байгууллага
1) Монгол Улсын ХАБЭА-н Үндэсний тогтолцоог төгөлдөршүүлэх зорилгоор Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 155, 161, 187, 197, 176, 183, 189, 201, 194, 164 дүгээр Конвенц, Зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангуулах талаар хамтарч ажиллах	ХНХЯ УУХҮЯ БХБЯ МОШПА
2) ХАБЭА-н Үндэсний хорооны үйл ажиллагааг нийгмийн түншлэлийн харилцааг хангах байнгын ажиллагаатай бүтэц болгон хөгжүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх	ХНХЯ ХАБЭА-Үндэсний хороо
3) ХАБЭА-н асуудлаар Засгийн газрын болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар НХХ-ийн сайд Н.Номтойбаярын гаргасан санаачлагын дагуу Нэн түрүүнд ХАБ бага хурлын үйл ажиллагааг үндэсний хэмжээний болгон өргөжүүлж, дэмжиж, Тогтвортой хамтын ажиллагааны төлөө хамтарч ажиллах	ХНХЯ ХАБЭА-н Үндэсний хороо ХАБЭМТ МОШПА ТББ
4) ХАБЭА-н хуулийн дагуу төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлын төсвийн зүйл ангид ХАБЭА-н зардал-төрлийг тусгайлан бий болгож, төсвийг төсөвлөх, гүйцэтгэлд хяналт тавих боломжийг бүрдүүлэх	ХНХЯ ХАБЭА-н Үндэсний хороо Сангийн яам

ЗОРИЛТ 2. ХАБЭА-Н ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Үйл ажиллагаа	Хамтран ажиллах байгууллага
1) ХАБЭА-н стандартуудад үзлэг хийж, шинэчлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	ХАБЭМТ СХЗГ МОШПА
2) “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэх, талуудын эрх үүргийг тодорхой болгох	Ажил олгогчид, ХАБЭА-н ажилтнууд
3) OHSAS 18001 стандартыг аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх	МОШПА, ажил олгогчид

ЗОРИЛТ 3. ХАБЭА-Н СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

Үйл ажиллагаа	Хамтран ажиллах байгууллага
1) Хөдөлмөр сонины редакц, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран гаргасан “Аюулгүй ажиллагааны үндэсний соёлыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийнхэн манлайлцгаая” уриалгыг дэмжиж ажиллах	ХАБЭА-н Үндэсний хороо Хөдөлмөр сонин Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл Хэвлэлийн хүрээлэн
2) ХАБЭА-н мэдээ, мэдээлэл, сайн туршлагыг түгээх зорилгоор “НЭН ТҮРҮҮНД ХАБ” сэтгүүлийг улирал тутам гаргах	ХАБЭА-н Үндэсний хороо Хөдөлмөр сонин МОШПА ТББ

ЗОРИЛТ 4. ХАБЭА-Н ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР

Үйл ажиллагаа	Хариуцагч
1) Нэн түрүүнд ХАБ-2017 Бага хуралд оролцогчид болон нийгмийн түншүүд, ажил олгогчдыг оролцуулан ХАБЭА-н үндэсний тав дахь хөтөлбөрийн төсөлд санал бэлтгэж хүргүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах	Нэн түрүүнд ХАБ Бага хурлын удирдах хороо МОШПА ТББ
2) Ажил олгогчийн ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх асуудлыг урамшуулах хөшүүрэг бүрдүүлэх чиглэлээр ҮО, МШӨ-ийн даатгалын тогтолцоог шинэчлэн өөрчлөх	ХНХЯ, ЭМНДЕГ, МҮЭ-ийн холбоо МАОЭНХ

ЗОРИЛТ 5. ХАБЭА-Н САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ

Үйл ажиллагаа	Хариуцагч
1) Ноцтой эрсдэлийн удирдлагын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа Оюу толгой ХХК-ийн сайн туршлагыг аж ахуйн нэгж байгууллагууд нэвтрүүлж ажиллах тухай хөтөлбөр гаргах	Оюу толгой ХХК МОШПА ТББ
2) ЖДҮ эрхлэгчдэд ХАБЭА-н сургалтыг ХАБЭМТ-тэй хамтран зохион байгуулах	ХАБЭМТ, ХХААХҮЯ МОШПА ТББ

Эдгээр зорилтынбиелэлтийг хангах талаар ХАБЭА-н Үндэсний хороотой идэвхитэй хамтран ажиллахаа НЭН ТҮРҮҮНД ХАБ-2017 бага хуралд оролцогчид илэрхийлэв.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн хяналтын тухай” 81, 129 дүгээр Конвенцэд нэгдэн орохыг оролцогчдоос дэмжив.

ХАБЭА-н сургалтын тогтолцоог сайжруулах талаар сургалтын бодлого тодорхойлогч Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн Төв, Мэргэшсэн ХАБЭА-н Мэргэжилтнүүдийн Холбоо ТББ, сургалтын байгууллагууд хамтран 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “ХАБЭА-н сургалт” сэдэвт семинарыг зохион байгуулахаар тохиролцов.

Нэн түрүүнд ХАБ-2018 Бага хурлыг Монголын Мэргэшсэн ХАБЭА-н Мэргэжилтнүүдийн Холбоо хариуцан зохион байгуулахыг хуралд оролцогчид үүрэг болгов.

БАГА ХУРАЛД ОРОЛЦОГЧИД